ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/101/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2025 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Одхүү<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:odkhuu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.......................................................................................... 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл......................................................5-9

3. Аудитын илрүүлэлт ..........................................................................................................14

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл..............................................................15

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| НА | Нийцлийн аудит |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ЗДНС | Засаг даргын нөөц сан |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЦДАШ | Цахилгаан дамжуулах агаарын шугам |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 307

танай 2025.01.23 -ны № 2/40 -т

ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БЯМБАСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 4 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг

011022116

хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 87.8 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **218,899,797.35** | **254,958,447.35** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 218,899,797.35 | 254,958,447.35 |
| **351** | **Түүхий эд материал** | 4,573,988.35 | 4,573,988.35 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,573,988.35 | 4,573,988.35 |
| **354** | **Хангамжийн материал** | 80,352,409.00 | 72,346,059.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 681,260.00 | 681,260.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 28,183,789.00 | 28,183,789.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 51,487,360.00 | 43,481,010.00 |
| 35600 | Мал амьтад | 133,973,400.00 | 178,038,400.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,498,743,958.24** | **7,530,824,542.47** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | - | - |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 5,498,743,958.24 | 7,530,824,542.47 |
| 39100 | Газар | - | 46,286,000.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,416,172,958.42 | 7,063,419,827.27 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 951,259,639.00 | 4,320,720,621.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (116,336,032.85) | (155,813,164.85) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 146,000,000.00 | 258,880,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (129,645,833.26) | (151,954,666.44) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 188,559,436.20 | 198,900,770.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (124,494,657.40) | (109,836,180.76) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 60,579,385.00 | 58,352,585.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (57,090,610.33) | (56,769,025.00) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 2,797,911,275.00 | 3,068,454,849.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (368,383,215.60) | (431,719,246.92) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 88,664,100.00 | 86,823,100.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (30,859,527.34) | (32,628,813.76) |
| 39217 | Ном | 10,009,000.00 | 10,009,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 11,103,219.82 | 33,955,609.20 |
| 39301 | Програм хангамж | 2,497,200.00 | 1,697,200.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,403,980.18) | (1,697,200.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,010,000.00 | 38,010,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | (4,054,390.80) |
| **394** | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | 2,071,467,780.00 | 387,163,106.00 |
| 39405 | Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ | 2,071,467,780.00 | 387,163,106.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,717,643,755.59** | **7,785,782,989.82** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,717,643,755.59** | **7,785,782,989.82** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,717,643,755.59 | 7,785,782,989.82 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 807,538,535.34 | 880,824,535.34 |
| 51101 | Өмч: - төрийн | 807,538,535.34 | 880,824,535.34 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,546,075,638.10 | 6,540,928,872.33 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,546,075,638.10 | 4,542,021,247.30 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,998,907,625.03 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 364,029,582.15 | 364,029,582.15 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,717,643,755.59** | **7,785,782,989.82** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,913,880,932.00** | **6,448,250,389.58** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **757,794,926.00** | **3,977,444,232.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 757,794,926.00 | 3,977,444,232.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 610,500.00 | 54,945,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 610,500.00 | 1,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 53,945,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 703,651,526.00 | 3,915,879,232.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 53,532,900.00 | 6,620,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,156,086,006.00** | **2,470,806,157.58** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 32,766,306.00 | 158,115,257.58 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,825,306.00 | 15,793,543.58 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,941,000.00 | 142,321,714.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,123,319,700.00 | 2,312,690,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,123,319,700.00 | 2,312,690,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,324,737,485.60** | **4,409,072,764.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,200,028,090.60** | **2,051,427,660.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,035,333,889.68 | 1,580,757,065.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 382,120,779.40 | 600,071,550.98 |
| 210101 | Үндсэн цалин | 245,770,427.37 | 367,955,326.51 |
| 210102 | Нэмэгдэл | 81,708,482.75 | 200,328,224.47 |
| 210104 | Урамшуулал | 12,233,182.83 | 31,788,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 42,408,686.45 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,915,982.18 | 69,062,718.37 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,893,183.10 | 47,518,007.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,709,296.92 | 5,959,381.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,874,926.18 | 2,848,971.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 605,084.48 | 2,077,252.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,833,491.50 | 10,659,105.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,295,770.50 | 46,460,056.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,853,044.50 | 3,577,021.95 |
| 210302 | Түлш, халаалт | 19,442,726.00 | 41,923,035.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 960,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,684,274.00 | 49,326,941.58 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,714,260.00 | 4,624,660.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,403,624.00 | 36,556,031.58 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,294,590.00 | 5,719,450.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 480,000.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,791,800.00 | 2,246,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,075,840.00 | 14,115,640.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 2,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,075,840.00 | 11,915,640.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,574,000.00 | 19,544,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,574,000.00 | 19,544,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,155,493.00 | 924,248.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 38,062.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 520,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,484,725.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 177,436.00 | 181,336.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 720,000.00 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 198,332.00 | 177,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 513,511,750.60 | 781,251,409.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 351,740,971.00 | 603,986,402.85 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 250,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 161,770,779.60 | 177,015,006.97 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 164,694,200.92 | 470,670,594.85 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 14,358,515.40 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 14,358,515.40 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 136,525,393.67 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 136,525,393.67 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 164,694,200.92 | 319,786,685.78 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 164,694,200.92 | 319,786,685.78 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **124,709,395.00** | **2,357,645,104.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 124,709,395.00 | 2,357,645,104.00 |
| 220001 | Барилга байгууламж | - | 2,003,894,600.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 124,709,395.00 | 353,750,504.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **589,143,446.40** | **2,039,177,625.03** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 13,625,000.00 | 40,270,000.00 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 13,625,000.00 | 40,270,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (13,625,000.00) | (40,270,000.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **575,518,446.40** | **1,998,907,625.03** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,156,696,506.00** | **2,471,806,157.58** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **610,500.00** | **1,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 610,500.00 | 1,000,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 610,500.00 | 1,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 610,500.00 | 1,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,156,086,006.00** | **2,470,806,157.58** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 32,766,306.00 | 158,115,257.58 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,825,306.00 | 15,793,543.58 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,941,000.00 | 142,321,714.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,123,319,700.00 | 2,312,690,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,123,319,700.00 | 2,312,690,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,031,987,111.00** | **1,890,176,303.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,031,987,111.00** | **1,890,176,303.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **867,292,910.08** | **1,419,505,708.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 382,120,779.40 | 600,071,550.98 |
| 210101 | Үндсэн цалин | 245,770,427.37 | 367,955,326.51 |
| 210102 | Нэмэгдэл | 81,708,482.75 | 200,328,224.47 |
| 210104 | Урамшуулал | 12,233,182.83 | 31,788,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 42,408,686.45 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,915,982.18 | 69,062,718.37 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,893,183.10 | 47,518,007.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,709,296.92 | 5,959,381.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,874,926.18 | 2,848,971.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 605,084.48 | 2,077,252.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,833,491.50 | 10,659,105.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,295,770.50 | 46,460,056.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,853,044.50 | 3,577,021.95 |
| 210302 | Түлш, халаалт | 19,442,726.00 | 41,923,035.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 960,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,565,474.00 | 49,873,991.58 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,714,260.00 | 4,624,660.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,284,824.00 | 36,556,031.58 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,294,590.00 | 5,719,450.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 480,000.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,791,800.00 | 2,793,850.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 1,204,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,204,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,125,640.00 | 23,334,990.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,049,800.00 | 2,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,075,840.00 | 21,134,990.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,574,000.00 | 19,544,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,574,000.00 | 19,544,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,155,493.00 | 924,248.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 38,062.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 520,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,484,725.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 177,436.00 | 181,336.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 720,000.00 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 198,332.00 | 177,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 343,539,771.00 | 609,029,152.85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 343,539,771.00 | 608,779,152.85 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 250,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **164,694,200.92** | **470,670,594.85** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 14,358,515.40 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 14,358,515.40 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 136,525,393.67 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 136,525,393.67 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 164,694,200.92 | 319,786,685.78 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 164,694,200.92 | 319,786,685.78 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **124,709,395.00** | **581,629,854.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **124,709,395.00** | **581,629,854.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **124,709,395.00** | **581,629,854.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 124,709,395.00 | 581,629,854.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 124,709,395.00 | 353,750,504.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 227,879,350.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(124,709,395.00)** | **(581,629,854.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 807,538,535.34 | 364,029,582.15 | 3,970,557,191.70 | 0.00 | **5,142,125,309.19** |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **807,538,535.34** | **364,029,582.15** | **3,970,557,191.70** | **0.00** | **5,142,125,309.19** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 575,518,446.40 | 0.00 | **575,518,446.40** |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **807,538,535.34** | **364,029,582.15** | **4,546,075,638.10** | **0.00** | **5,717,643,755.59** |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **807,538,535.34** | **364,029,582.15** | **4,546,075,638.10** | **0.00** | **5,717,643,755.59** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -4,054,390.80 | 0.00 | **-4,054,390.80** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **807,538,535.34** | **364,029,582.15** | **4,542,021,247.30** | **0.00** | **5,713,589,364.79** |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 73,286,000.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **73,286,000.00** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 1,998,907,625.03 | 0.00 | **1,998,907,625.03** |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **880,824,535.34** | **364,029,582.15** | **6,540,928,872.33** | **0.00** | **7,785,782,989.82** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,123,919,700.00** | **1,123,567,300.00** | **2,320,228,040.45** | **1,857,378,820.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 961,297,300.00 | 998,857,905.00 | 1,633,279,340.45 | 1,285,748,666.55 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 961,297,300.00 | 840,227,604.08 | 1,616,506,240.45 | 1,271,390,151.15 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 434,706,100.00 | 381,352,779.40 | 732,584,200.00 | 600,071,550.98 |
| 210101 | Үндсэн цалин | 358,223,300.00 | 245,770,427.37 | 409,932,300.00 | 367,955,326.51 |
| 210102 | Нэмэгдэл | - | 81,708,482.75 | 288,915,900.00 | 200,328,224.47 |
| 210104 | Урамшуулал | 28,769,400.00 | 11,465,182.83 | 33,736,000.00 | 31,788,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 47,713,400.00 | 42,408,686.45 | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 56,632,200.00 | 44,915,982.18 | 91,805,840.45 | 69,062,718.37 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,890,000.00 | 31,893,183.10 | 62,563,100.00 | 47,518,007.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,435,700.00 | 3,709,296.92 | 7,360,100.00 | 5,959,381.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,029,400.00 | 3,874,926.18 | 4,553,600.00 | 2,848,971.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,041,000.00 | 605,084.48 | 2,608,240.45 | 2,077,252.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,236,100.00 | 4,833,491.50 | 14,720,800.00 | 10,659,105.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,560,000.00 | 22,295,770.50 | 58,316,800.00 | 46,460,056.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,500,000.00 | 2,853,044.50 | 8,236,600.00 | 3,577,021.95 |
| 210302 | Түлш, халаалт | 22,060,000.00 | 19,442,726.00 | 49,120,200.00 | 41,923,035.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | - | 960,000.00 | 960,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 38,480,800.00 | 37,323,168.00 | 39,442,400.00 | 36,344,064.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,740,000.00 | 3,714,260.00 | 3,742,600.00 | 3,714,660.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,544,000.00 | 26,042,518.00 | 24,494,100.00 | 23,936,104.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,925,000.00 | 5,294,590.00 | 7,044,000.00 | 5,719,450.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 480,000.00 | 480,000.00 | 626,700.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,791,800.00 | 1,791,800.00 | 3,535,000.00 | 2,793,850.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | - | 1,401,400.00 | 1,204,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | - | 1,401,400.00 | 1,204,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын** | 18,471,500.00 | 18,125,640.00 | 38,841,700.00 | 33,334,690.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,142,900.00 | 2,049,800.00 | 14,680,400.00 | 12,199,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын | 78,600.00 | - | 661,300.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 16,250,000.00 | 16,075,840.00 | 23,500,000.00 | 21,134,990.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 20,950,000.00 | 12,494,000.00 | 16,600,000.00 | 15,540,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,950,000.00 | 12,494,000.00 | 16,600,000.00 | 15,540,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,771,000.00 | 3,155,493.00 | 5,977,700.00 | 924,248.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,512,600.00 | - | 3,503,600.00 | 38,062.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 520,000.00 | 520,000.00 | 520,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,500,000.00 | 1,484,725.00 | 342,300.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 200,900.00 | 177,436.00 | 224,100.00 | 181,336.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 55,000.00 | 141,600.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 728,000.00 | 720,000.00 | 1,068,700.00 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 199,500.00 | 198,332.00 | 177,400.00 | 177,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 361,725,700.00 | 320,564,771.00 | 631,536,200.00 | 468,448,322.85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 361,225,700.00 | 320,564,771.00 | 630,982,700.00 | 468,198,322.85 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | - | 553,500.00 | 250,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 158,630,300.92 | 16,773,100.00 | 14,358,515.40 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - | 16,773,100.00 | 14,358,515.40 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | - | 16,500,000.00 | 14,358,515.40 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - | 273,100.00 | - |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | - | 158,630,300.92 | - | - |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 158,630,300.92 | - | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **162,622,400.00** | **124,709,395.00** | **686,948,700.00** | **571,630,154.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 162,622,400.00 | 124,709,395.00 | 686,948,700.00 | 571,630,154.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 162,622,400.00 | 124,709,395.00 | 686,948,700.00 | 571,630,154.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,123,919,700.00** | **1,123,930,200.00** | **2,317,192,240.45** | **1,857,378,820.55** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,123,319,700.00** | **1,123,319,700.00** | **2,316,592,240.45** | **1,856,378,820.55** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,047,448,400.00 | 1,047,448,400.00 | 2,316,592,240.45 | 1,856,378,820.55 |
| 300001 | Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/ | 75,871,300.00 | 75,871,300.00 | - | - |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 600,000.00 | 610,500.00 | 600,000.00 | 1,000,000.00 |
| 120010 | Туслах үйл ажиллагааны орлого | 600,000.00 | 610,500.00 | 600,000.00 | 1,000,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - | - | - |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН** | - | - | - | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | - | - | - |
| 610001 | Төсвийн байгууллага | | | | |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 27.00 | 24.00 | 27.00 | 22.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 8.00 | 8.00 | 8.00 | 7.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 10.00 | 13.00 | 9.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | | | | |
| 620004 | Гэрээт ажилтан | 6.00 | 6.00 | 6.00 | 6.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **158,115,257.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **158,115,257.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 158,115,257.58 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,529,927.58 |
| 210401 | Бичиг хэрэг | 910,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,619,927.58 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,004,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,004,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 140,580,830.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 140,580,830.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 158,115,257.58 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 158,115,257.58 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,793,543.58 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 142,321,714.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 129,764.5 мянган төгрөгийн 5 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

*Залруулсан алдаа:*

- Тайлант хугацаанд газрын нэгдсэн санд бүртгэлтэй байгууллагын эзэмшлийн гэрчилгээтэй 73,286.0 мянган төгрөгийн газрыг бүртгэл, тайланд тусгахдаа Засгийн газрын сан дансанд тусгаагүй нь Сангийн Сайдын 2018 оны 207 тугаар тушаалаар батлагдсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- Үндсэн хөрөнгийн дансанд 2021 онд бүртгэсэн 67,625.1 мянган төгрөгийн "Чух багийн ЦДАШ-ын өргөтгөл" нэртэй хөрөнгөнд 4,054.4 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй нь УСНББОУС 17 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.7 дахь "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Тайлант хугацаанд бүртгэлд авсан 73,286.0 мянган төгрөгийн газарт 3,894.1 мянган төгрөгийн элэгдэл тооцон зардлаар бүртгэсэн нь Сангийн Сайдын 2018 оны 207 тугаар тушаалаар батлагдсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- "Хүүхэд эрдэнэ" хүүхэд хамгааллын төслийн хүрээнд хүлээн авсан 3 нэр төрлийн 1,110.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал тусгана, УСНББОУС -17, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- Тайлант хугацааны 47,420.0 мянган төгрөгийн малын нас дэвшилтийг тооцож данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал тусгана, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.

Аудитаар нийт 5,864.6 мянган төгрөгийн 2 зөрчил[2] илэрснээс, 5,864.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон.

### 3.1 Төлбөрийн акт

1. Онцгой байдлын газраас түймэрт зарцуулсан шатахууны 5,333.9 мянган төгрөг, төрийн албан хаагчаас орон сууцны халаалтын үнийн 502.4 мянган төгрөг нийт 5,836.3 мянган төгрөгийг нэхэмжлэн авсан байна. ЗДТГ нь түймрийн зардлыг ЗДНС болон төсвөөсөө зарцуулсан бөгөөд оны эцэст уг орлогоор шатахууны талон худалдан авч бараа материалын дансанд бүртгээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “*Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”,* 12.1.4 дэх “*хуулиар зөвшөөрөөгүй бусад”,* 15.1.6 дахь "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэсэн заалтуудыг зөрчсөн, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тайлант хугацаанд албан хаагчийн цалинг 28.3 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| газрыг бүртгэл, тайланд тусгахдаа Засгийн газрын сан дансанд тусгаагүй | 1 | 73,286.0 | - | - | 1 | 73,286.0 | - | - | - | - | - | - |
| 67.6 сая төгрөгийн "Чух багийн ЦДАШ-ын өргөтгөл" нэртэй хөрөнгөнд элэгдэл тооцоогүй | 1 | 4,054.4 | - | - | 1 | 4,054.4 | - | - | - | - | - | - |
| газарт 3.8 сая төгрөгийн элэгдэл тооцон зардлаар бүртгэсэн | 1 | 3,894.1 | | | 1 | 3,894.1 | - | - | - | - | - | - |
| "Хүүхэд эрдэнэ" хүүхэд хамгааллын төслийн хүрээнд хүлээн авсан 3 нэр төрлийн тоног төхөөрөмжийг бүртгэл тайланд тусгаагүй | 1 | 1,110.0 | 1 | 1,110.0 | - | - | - | - | - | - | - | - |
| Тайлант хугацааны малын нас дэвшилтийг тооцож данс бүртгэлд тусгаагүй байна | 1 | 47,420.0 | 1 | 47,420.0 | -- | | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **5** | **129,764.5** | **2** | **48,530.0** | **3** | **81,234.5** | - | - | - | - | - | - |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ нь түймрийн зардлыг ЗДНС болон төсвөөсөө зарцуулсан бөгөөд оны эцэст уг орлогоор шатахууны талон худалдан авч бараа материалын дансанд бүртгээгүй байна. | 1 | 5,836.3 | 1 | 5,836.3 | | | | |
| Тайлант хугацаанд албан хаагчийн цалинг 28.3 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. | 1 | 28.3 | 1 | 28.3 | | | | |
| **Дүн** | **2** | **5,864.6** | **2** | **5,864.6** | | | | |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр Дугаар 04 20А-2025/101/НА-СТА-ТШЗ А 1170308 Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Онцгой байдлын газраас түймэрт зарцуулсан шатахууны 5.3 сая төгрөг, төрийн албан хаагчаас орон сууцны халаалтын үнийн 0.5 сая төгрөг нийт 5.8 сая төгрөгийг нэхэмжлэн авсан байна. Түймрийн зардлыг Засаг даргын нөөц сан болон төсвөөсөө зарцуулсан бөгөөд оны эцэст уг орлогоор шатахууны талон худалдан авч бараа материалын дансанд бүртгэлгүй, шууд зардлаар гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "*Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх "хуулиар зөвшөөрөөгүй бусад"*, 15.1.6 дахь "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх "*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*", 14.4.1-д "*аж ахуйн бүх ажил, гүйлгээ*" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 дахь "*Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн*" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бүртгэл тайланд тусгалгүй зарцуулсан 5,836,283 /Таван сая найман зуун гучин зургаан мянга хоёр зуун наян гурван/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Ц.Бямбасүрэн, нягтлан бодогч Б.Боргилмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АУДИТОР Б.ОДХҮҮ

2117144066
ХТУ4037 9030891

2125050097

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр Дугаар 15 ДОН-2025/101/НА-СТА-ТШЗ. А 11170308 Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын 1 албан хаагчийн цалинг 28.3 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "*Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно*", 12.1.4-д "*хуулиар зөвшөөрөөгүй бусад*", *Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн* 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3 дахь "*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 28,327 /Хорин найман мянга гурван зуун хорин долоон/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Ц.Бямбасүрэн, нягтлан бодогч Б.Боргилмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АУДИТОР Б.ОДХҮҮ

2117144006
ХТҮ4037 8030891

2125050100